



УВС АЙМАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Улаангом

Журам батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2 16.5.5 дэх заалт, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 53/45 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилгоор уралдаан тэмцээний үед шүүгчээр ажилласан шүүгчийн ажлын хөлснийг тооцох журмыг 1 дүгээр, аймгийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн шагналын хэмжээг 2 дугаар, зааланд чөлөөт тоглолт, үзвэр үзэх, тэмцээний мандат, зэргийн үнэмлэх, фитнесээр хичээллэгчдээс авах төлбөр хураамжийг 3 дугаар, Спорт ордон, спорт заалаар үйлчлэх журмыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан Биеийн тамир спортын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/03 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.БАЯРТУУЛ



Биеийн тамир, спортын газрын даргын
2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн
А/02 тоот тушаалын 1 дүгээр хавсралт




Спортын төрөл бүрийн арга хэмжээ, уралдаан тэмцээний
үед ажилласан шүүгчийн ажлын хөлсийг
тооцох журам

№	Шүүгчийн ангилал	Ажлын хөлс /Нэг өдрийн/ төгрөг
1	2	3
1	Олон улсын шүүгч	50,000
2	Улсын шүүгч	40,000
3	Шүүгч	25,000

- Өөрийн байгууллагын ажилтан, дасгалжуулагч нар амралт, баяр ёслолын өдрүүдэд шүүгчээр ажилласан үед нь шүүгчийн ажлын хөлсийг нь олгох, аль эсвэл ажилтан өөрөө хүсвэл биеэр амралтыг нь нөхөж эдлүүлэх бөгөөд амарч чадаагүй тохиолдолд ээлжийн амралт дээр нь тооцож олгож болно.
- Тэмцээний үед ажилласан их эмчийг улсын шүүгчтэй, бага эмч, засуулыг шүүгчийн ажлын хөлсөөр адилтгана үзнэ.

-----oOo-----




Аймгийн аварга шалгаруулах тэмцээний
мөнгөн шагналын хэмжээ

1. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр, насанд хүрэгчдийн ангилалаар тухайн спортын холбоодтой хамтран жил бүр зохион байгуулах бөгөөд тухайн жилийн төлөвлөгөө, графикт тусгагдаж баталгаажсан байна.
2. Өсвөр болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний шагналыг тухайн спортын төрөлд оролцогчдын хамрах хүрээ, нас, жин, зай, төрөл, ганцаарчилсан болон багийн спортын төрлөөс хамааран дараах байдлаар олгоно.
 - а. Насанд хүрэгчид:
 - 1-р байр 50,000-100,000 төгрөг
 - 2-р байр 40,000-80,000 төгрөг
 - 3-р байр 30,000-50,000 төгрөг
 - б. Өсвөр үе
 - 1-р байр 30,000-50,000 төгрөг
 - 2-р байр 20,000-40,000 төгрөг
 - 3-р байр 15,000-30,000 төгрөг
3. Өсвөр болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах эрхийг тухайн спортын холбоодод олгох бөгөөд тухайн спортын холбоодоор дамжуулан мөнгөн шагналыг олгоно.

-----oOo-----

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн
А/02 тоот тушаалын 3 дугаар хавсралт



Зааланд чөлөөт тоглолт, үзвэр үзэх, тэмцээний мандат,
зэргийн үнэмлэх, фитнесээр хичээллэгчдээс
авах төлбөр хураамж

Спортын уралдаан тэмцээнд оролцох, спортын ордон, спорт зааланд чөлөөт тоглолтоор үйлчлүүлэх, спортын цол зэрэг олгох, фитнес клубт хичээллэгчдээс авах төлбөр хураамжийг дараах байдлаар ангилна.

1. Зааланд цагаар чөлөөт тоглолт тоглох
 - Хүүхэд -1000 төгрөг
 - Насанд хүрэгчид -3000 төгрөг
2. Үзвэрийн үнэ:
 - Улс, бүс, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит, бусад уралдаан тэмцээний үед хүүхэд-1000 төгрөг, насанд хүрэгчид-3000 төгрөг
3. Мандатын үнэ:
 - Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнд оролцогчдын хураамж буюу мандатын үнэ өсвөр үе-5000 төгрөг, насанд хүрэгчид-10,000 төгрөг байна.
 - Баруун бүс, олон хотын нэрэмжит, улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулахад тэмцээнд оролцогчдын хураамж буюу мандатын үнэ өсвөр үе-10,000 төгрөг, насанд хүрэгчид-20,000 төгрөг байна.
4. Фитнес клубт хичээллэх:
 - Иргэд чөлөөт цагаараа бие бялдраа чийрэгжүүлэх, фитнес клубт хичээллэхэд авах төлбөр хураамжийг дараах байдлаар тогтооно.
 - Хүүхэд 1 удаагийн бэлтгэл хийхэд 2000 төгрөг, 1 сарын төлбөр-30,000 төгрөг
 - Насанд хүрэгчид 1 удаагийн бэлтгэл хийхэд-5000 төгрөг, 1 сарын төлбөр 50,000 төгрөг тус тус байна.
5. Зэргийн үнэмлэх
 - Спортын цол зэргийн нэгдсэн ангиллын 1, 2, 3 дугаар зэргийн болзол биелүүлсэн тамирчид, шүүгчдэд олгох зэргийн үнэмлэхийн хураамж 10,000 төгрөг байна.

-----oO-----

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн
А/02 тоот тушаалын 04 дүгээр хавсралт


Спорт ордон, спорт заалаар үйлчлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. Энэхүү журам нь Биеийн тамир, спортын газрын "А","Б" зааланд спортын болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, ашиглуулах, түрээслэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. БТС-ын газрын үйл ажиллагааны чиглэл, зорилготой уялдуулан заал ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 1.3. Түрээслэгч нь заал танхимыг ашиглах талаар тодорхой мэдээлэлийг биеийн тамирын болон, спортын хэлтэст 1 /нэг /-ээс доошгүй сарын өмнө урьдчилан мэдэгдэж, график, төлөвлөгөөнд тусгуулан гэрээ байгуулж, зохих тарифын дагуу төлбөрийг хийнэ.
- 1.4. Түрээслэгч талын хүсэлтийг албан бичгээр болон амаар хүлээн авч заал ашиглуулсны хариуцлагын гэрээ байгуулна.
- 1.5. Заал ашиглахтай холбогдсон өдөр тутмын үйл ажиллагааг заал зохион байгуулагч хариуцах үүрэгтэй бөгөөд байгууллагын даргын өмнө хариуцлага хүлээнэ.
- 1.6. Заалны орлогыг заалны засвар үйлчилгээ, цэвэрлэгээний материал, хэрэглэл худалдан авах, илүү цагаар ажилласан үйлчилгээний ажилчдын урамшуулалд зарцуулж болно.
- 1.7. Заал ашиглах түрээсийн гэрээ, төлбөр тооцооны гүйцэтгэлд нягтлан бодогч хяналт тавин ажиллах ба биелэлт, хэрэгжилтийн явцын талаар газрын даргад танилцуулж байна.

Хоёр. Заалны цаг, ашиглалт, дотоод журам

- 2.1 Зааланд зохиогдох аливаа арга хэмжээний үргэлжлэх хугацаа 5 /тав/ цаг хүртэл бол цагийн, түүнээс дээш хугацааг бүтэн өдрийн тарифаар тооцох ба оройн 22.00 цагаас хойш илүү цагийн төлбөр авна.
- 2.2 Заалыг гэрээнд заасан нөхцөл зориулалтын дагуу ашиглах бөгөөд спортын ордон болон заалны эд хогшлийг эвдэлж гэмтлэх, тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.



- 2.3 Амралтын өдөр түрээсэлж байгаа тохиолдолд заал ашиглахтай холбоотойгоор ажиллуулах үйлчилгээний ажиллагсдын илүү цагийн хөлсийг тооцон түрээсийн төлбөр дээр нэмж авна.
- 2.4 Тэмцээний удирдамж, шүүгчдийн бүрэлдэхүүн, спортын хэрэгсэл, материал хангамжтай холбогдсон асуудлыг түрээслэгч өөрөө шийдвэрлэх бөгөөд гадна талбай болон заал танхимд тавигдах реклам, сурталчилгааны материалыг түрээслүүлэгч талтай тохиролцсоны үндсэн дээр байрлуулах буюу заалны зохион байгуулагчид хүлээлгэн өгнө.
- 2.5 Түрээслэгч талд шаардлагатай эд зүйлс, заал танхимыг тэмцээн эхлэх цагаас 30-60 минутын өмнө бэлэн болгож хүлээлгэн өгнө.
- 2.6 Заал ашиглуулсаны хариуцлагын гэрээ байгуулсан боловч арга хэмжээ зохиогдохоос гурав хоногийн өмнө төлбөр тооцоогоо хийгээгүй тохиолдолд гэрээг хүчингүй болгон цуцалж болно.
- 2.7 ЕБС-ын сурагчид ба 18-аас доош насны иргэдэд өвлийн улиралд 18.00 цагаас, зуны улиралд 20.00 цагаас хойш спортын уралдаан тэмцээн, сургалт дасгалжуулалтын үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.
- Гурав. Төлбөр тооцоо
- 3.1 Спорт ордонд чөлөөт тоглолт, биеийн тамирын арга хэмжээний цагийн хөлс нь 50.000 /Тавин мянган / төгрөг, спорт заал 30,000 төгрөг, байгууллага, хамт олноороо биеийн тамир, спортоор хичээллэх зорилгоор гэрээ байгуулан ажиллах тохиолдолд сарын түрээсийн төлбөр нь 200.000 төгрөг байна.
- 3.2 Амралтын өдрүүдээр спортын ордон, спорт зааланд уралдаан тэмцээн зохион байгуулах тохиолдолд нэг өдрийн түрээсийн төлбөр 300.000 төгрөг байна.
- 3.3 Соёл урлагийн арга хэмжээ, урлагийн тоглолт, хамтлаг, дуучдын тоглолтын түрээсийн төлбөр өдрийн 1000,000 төгрөг;
- 3.4 Шашны аливаа зан үйл /бясалгал, номлол, хурал, цуглаан, спортын бус арга хэмжээ зохион байгуулахад заалны түрээсийн төлбөр /Спортын ордонд/ өдрийн 500.000 төгрөг, спорт зааланд 300.000 төгрөг байна.
- 3.5 Төрийн захиргааны төв байгууллага, спортын холбоод, хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдийн төлөөх олон нийтийн байгууллагаас зохион байгуулж буй хандивын тоглолт, спорт, урлагийн арга хэмжээ зохион байгуулагдах тохиолдолд байгууллагын даргын зөвшөөрөлтэйгээр үнэ төлбөргүй болон 50 хүртэл хувийн хөнгөлөлттэй тарифаар ашиглуулна.